



**ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

**Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн  
албан шаардлагыг биелүүлэх  
зардал гаргах тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дэх заалт, “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.3.18 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 6-р хороо, их тойруу, 53/3 хаягт байрлах “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн барилга, байгууламжийн галын аюулгүй байдлыг хангах талаар дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 022/28 дугаар албан шаардлагын хэрэгжилтийг зохион байгуулж, шаардагдах 11,018,500 *арван нэгэн сая арван найман мянга таван зуун* төгрөгийн зардлыг компанийн 2023 оны батлагдсан төсөвт багтаан шийдвэрлэхийг Гүйцэтгэх захирал /Б.Эрдэнэбулган/-д зөвшөөрсүгэй.

2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга /Б.Мөнхцэцэг/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ц.ШИНЭХҮҮ